



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

┌ Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн ┐
зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр шинэчлэн бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 451 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг бүртгэх тухай журам”-ын дагуу үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх хуулийн компаниар бүртгэгдсэн дараах нөхөрлөлүүдийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр шинэчлэн бүртгэсүгэй:

1. “Өмгөөллийн Жи Ти Эс адвокатс” ХХН;
2. “Өмгөөллийн хууль зүйн билиг консалтинг” ХХН;
3. “Өмгөөллийн хаан лекс” ХХН;
4. “Өмгөөллийн Монгол өмгөөлөгч” ХХН;

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг дээрх нэр бүхий нөхөрлөлүүдийн захирлуудад үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000044